ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

“Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн одоогийн зохион байгуулалтын бүтцийг толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 57 дугаар тогтоолоор Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Нэгдсэн стратеги төлөвлөлтийн газар болон **5 хэлтэст** нийт **31 орон тоотойгоор** баталсан.

Бүтэц, орон тооны хязгаарт нийцүүлэн Монгол Улсын стратегийн орд болох Оюу Толгой ордын Монголын талын 34%-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэн, Хувьцаа эзэмшигчийн хувиар “Оюу Толгой” ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох, Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

